



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/02/-НА-СТА-ААТҮГ

Цахим www.audit.mn Алтай хот 2022 он	хуудас:	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр	
		Утас: 70483413 Цахим tuvshinbayarkh@audit.gov.mn	хаяг:
		Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	
		Утас: 70484055 Цахим erdenechimegd@audit.gov.mn	хаяг:
		Аудитор Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	Error! Bookmark not defined.
3.8 Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ДАРИВ СУМЫН "ЭРЧИМ ХҮЧ
ААТҮГ"-ЫН ДАРГА М.БАТЗАЯА
ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.15 № 169

танай _____ -ны № _____ -т

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дарив сумын "Эрчим хүч ААТҮГ"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Дарив сумын "Эрчим хүч ААТҮГ"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд Нүүрс болон тээврийн хөлс төлсөн гэх боловч зарцуулсан баримтгүй бөөн дүнгээр зарлагдсан, орлого тодорхой бус анхан шатны баримт хангалтгүй нүүрсний тайлан гаргаагүй өглөг авлага тооцох боломжгүй, тээвэр шатахууны хувьд жолоочийн тооцооны хуудасгүй анхан шатны баримтгүй, шатахууны тайланг гаргаагүй, нягтлан бодох бүртгэлд шууд зардалд бичсэн, шилэн дансны байршуулах мэдээллийг хангалтгүй мэдээлсэн, Е баримтгүй гүйлгээ хийсэн, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт 2 зөрүүтэй, өмнөх онд өглөгөөр тайлагнасан 2 иргэнд олгох нүүрсний өглөг 9.6 сая төгрөгийг төлөөгүй байхад өглөггүй тайлагнаж хасагдсан, Мон Эко ХХК өглөг 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нотлох боломжгүй, өглөгөөр огт тайлагнаагүй 1 иргэнд 4.8 сая төгрөгийн өр төлсөн гэх боловч нотлогдохгүй, цалингийн цэс, дансны хуулга тулгахад 5 дугаар сарын 5.4 сая төгрөгийн амралтын цалингийн цэс байхгүй, урьдчилгаа дутуу суутгасан, зээлийн гэрээнээс илүү мөнгө шилжүүлсэн, худалдан авах ажиллагаа зарлаагүй, төрөөс хариуцах халаалтын орлогыг илүү нэхэмжилж авсан, нийцлийн аудитаар тавигдсан актыг өөр ажилтнаас суутгаж барагдуулсан зэрэг нийт 370.6 сая төгрөгийн зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаартай тогтоол, Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчсөн бөгөөд АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

07020454

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ХТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,840,794.09	90,524,331.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	739,050.09	7,301,170.11
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31110	Төгрөг	0.00	0.00
31120	Гадаад валют	0.00	0.00
31130	Нэмэлт санхүүжилт	0.00	0.00
31140	Касс арилжааны банк	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	739,050.09	7,301,170.11
31210	Төгрөг	739,050.09	7,301,170.11
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31212	Монгол банкин дахь харилцах	0.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	739,050.09	7,301,170.11
33	АВЛАГА	20,705,204.00	14,446,293.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,250,000.00	0.00
33500	Бусад авлага	19,455,204.00	14,446,293.30
33510	Байгууллагаас авах авлага	15,238,000.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,217,204.00	14,446,293.30
34714	Томилолтын урьдчилгаа	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	20,396,540.00	73,570,700.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	20,396,540.00	73,570,700.00
35400	Хангамжийн материал	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	343,450,296.60	305,165,469.60
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	343,450,296.60	305,165,469.60
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	331,232,296.60	292,947,469.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	493,659,660.00	493,659,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-205,115,262.40
		165,724,725.40	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,300,000.00	10,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,300,000.00	-10,300,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	68,121,400.00	75,696,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,978,838.00	-72,255,128.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,917,500.00	2,917,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,762,700.00	-1,955,700.00
39209	Зам, гүүрийн байгууламж	0.00	0.00
39300	Биет бус хөрөнгө	12,218,000.00	12,218,000.00
39301	Програм хангамж	0.00	0.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,218,000.00	12,218,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	385,291,090.69	400,483,633.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	84,464,558.22	105,865,366.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	84,464,558.22	105,865,366.89
41200	Богино хугацаат зээлийн өглөг	18,079,224.80	16,748,821.00
41210	Төгрөг	18,079,224.80	16,748,821.00

41216	Арилжааны банк	18,079,224.80	16,748,821.00
41300	Өглөг	66,385,333.42	89,116,545.89
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	38,378,453.42	31,761,544.39
41360	Бусад өглөг	28,006,880.00	57,355,001.50
41361	Байгууллагад төлөх өглөг	28,006,880.00	18,844,185.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	31,400,000.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	7,110,816.50
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	300,826,532.47	289,824,433.82
51	Засгийн газрын хувь оролцоо	300,826,532.47	404,723,318.21
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	167,808,280.38	167,808,280.38
51200	Хуримтлагдсан үр дүн	121,561,652.09	115,353,385.74
51210	Өмнөх үеийн үр дүн	140,593,994.75	121,561,652.09
51220	Тайлант үеийн үр дүн	-19,032,342.66	-6,208,266.35
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,456,600.00	11,456,600.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	385,291,090.69	400,483,633.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	62,744,323.63	79,857,085.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,744,323.63	79,857,085.70
120	Нийтлэг татварын бус орлого	62,744,323.63	79,857,085.70
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	107,668.99	0.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	262,257,398.75	269,869,924.50
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	199,620,744.11	190,012,838.90
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,758,618.29	86,065,352.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	24,842,721.00	31,560,200.00
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	0.00	0.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	6,915,897.29	8,645,325.00
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,018,048.00	45,859,827.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	50,018,048.00	45,859,827.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-19,032,342.66	-6,208,266.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-19,032,342.66	-6,208,266.30
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,808,280.38	11,456,600.00	140,593,994.75	319,858,875.13
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	167,808,280.38	11,456,600.00	140,593,994.75	319,858,875.13
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-19,032,342.66	-19,032,342.66
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	167,808,280.38	11,456,600.00	121,561,652.09	300,826,532.47
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	167,808,280.38	11,456,600.00	121,561,652.09	300,826,532.47
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	167,808,280.38	11,456,600.00	121,561,652.09	300,826,532.47
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,208,266.35	-6,208,266.35
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	167,808,280.38	11,456,600.00	115,353,385.74	294,618,266.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	261,785,296.11	317,436,134.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	261,785,296.11	317,436,134.69
120	Нийтлэг татварын бус орлого	261,785,296.11	317,436,134.69
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	107,668.99	0.00
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	261,677,627.12	317,436,134.69
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	221,697,459.07	254,882,543.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	221,697,459.07	254,882,543.80

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,697,459.07	254,882,543.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	95,039,569.00	99,017,735.00
210101	Үндсэн цалин	0.00	0.00
210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	0.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	95,039,569.00	99,017,735.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,837,092.00	13,367,394.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	12,837,092.00	13,367,394.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,995,978.55	16,119,264.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	0.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	20,995,978.55	16,119,264.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,188,111.52	84,443,930.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	83,717,702.52	77,881,810.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	8,470,409.00	6,562,120.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	636,708.00	41,934,220.80
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	294,648.00	40,980,663.58
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	0.00	0.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	342,060.00	953,557.22
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	115,558,065.41	122,258,470.87
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115,558,065.41	122,258,470.87
2200	Дотоод эх үүсвэрээр	115,558,065.41	122,258,470.87
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	240,000.00	6,740,000.00
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/	115,318,065.41	115,518,470.87
2260	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
226001	Гадаад эх үүсвэрээр	0.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-115,558,065.41	-122,258,470.87

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	76,050,000.00	66,267,000.00
14	Бусад эх үүсвэр	76,050,000.00	66,267,000.00
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	76,050,000.00	66,267,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	579,771.63	6,562,120.02
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	159,278.46	739,050.09
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	739,050.09	7,301,170.11

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Сүнжидмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ нь хүний хөгжил, дэвшилтэд технологид түшиглэн үр ашигтай үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан дулаан эрчим хүчээр тасралтгүй хангах байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 199.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын дүн болох 233.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 4.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын бага үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажилагаа

Дарив сумын “Эрчим хүчний” ААТҮГ-ын зорилго нь хүний хөгжил, дэвшилтэд технологид түшиглэн үр ашигтай үйлдвэрлэл явуулж, стандартын шаардлага хангасан дулаан эрчим хүчээр тасралтгүй хангахад оршино.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд дулааны үйлдвэрлэл явуулах статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмч эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ нь: Дарив сумын ИТХ-ын тогтоолоор 1978 онд Дарив сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах гэсэн заалттай нийцэж байна.

Дарив сумын “Эрчим хүч” ААТҮГ -ын удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийг орон нутагт тухайн шатны ИТХ хэрэгжүүлэхээр заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т/Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулж дүгнэж ажиллах арга хэмжээ авсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх,

удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог нэмэгдүүлээгүй, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоол

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	739.5	7,301.2	6,562.1
БХХО			
Авлага	20,705.2	14,446.3	-6,258.9
Урьдчилгаа			
Бараа материал	20,396.5	73,570.7	53,174.2
Үндсэн хөрөнгө	343,450.3	305,165.4	-38,284.8
Биет бус хөрөнгө	12,218.0	12,218.0	0
Нийт хөрөнгийн дүн	385,291.0	400,483.6	15,192.5
Өр төлбөрийн дүн			
Богино хугацаат өглөг	84,464.5	105,865.4	21,400.8
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч	300,826.5	294,618.3	-6,208.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	385,291.0	400,483.6	15,192.5

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлгүй, банк дахь мөнгөний үлдэгдэлд 7.3 сая төгрөг байна.

Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд хугацаатай гаргасан үнэт цаас байхгүй болно.

Авлагын үлдэгдэлд халаалтын авлага 1.2 сая төгрөг, бусад хувь иргэнээс авах авлага 5.2 сая төгрөг, айл өрхөөс авах усны авлага 8.0 сая төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд 9.6 сая төгрөгийн авлагатай гэж тайлагнаж орж ирсэн боловч аудитаар давтан тооцоолж айл өрхөөс авах 4.7 сая төгрөгийн авлага нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа 14.4 сая төгрөгийг ААТҮГ нь Э-тайланд 0-1 насжилттай авлага барагдуулах боломжтой гэж үзсэн байна.

Тайлант онд 6.7 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн бөгөөд үүнээс 3.8 сая төгрөгийн суутган тооцож 3.7 сая төгрөгийг урьдчилгааг суутгаагүй боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 73.6 сая төгрөг болж 53.2 сая төгрөгөөр өссөн өмнөх онуудад шатах тослох материалыг тайланд тусгадаггүй, тайланд онд бүртгэсэнтэй холбоотой.

Тайлант онд худалдан авсан болон үнэ төлбөргүй ирсэн хөрөнгөөр байхгүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй 0.4 сая төгрөгийн бараа материал байна. Энэ нь тайланд он шинээр засвар сольсонтой холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 305.1 сая төгрөг болж 38.2 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой.

Биет бус хөрөнгөнд өөрчлөлт ороогүй бөгөөд 12.2 сая төгрөг байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэлгүй бөгөөд тайланд онд бүртгэсэн хөрөнгө оруулалт байхгүй болно.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 105.8 сая төгрөгийн өр төлбөр бүртгэсэн хэдий аудитаар өглөгийг нотлох боломжгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад зардал 37.0 сая нэмэгдсэн бөгөөд урсгал үйл ажиллагаа болон шугам сүлжээний засвар шинэчлэлтэй холбоотой.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дарив сумын Эрчим хүч ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дарив сумын Эрчим хүч ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Аймгийн Засаг дарга баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 267.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 248.1 сая төгрөгөөр, 19.8 сая төгрөгийн ашигтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 269.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 276.1 сая төгрөгийн зардал гарган, (-6.2) сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь уухын зуухны мотор халуун усны шугам сүлжээний шинэчлэл хийсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлж байгаа өглөгийн зардлыг баталгаажуулах боломгүй, нярвын тайлан байхгүй, түлээ нүүрс тээвэр шатахууны зардлыг тооцох боломжгүй, анхан шатны баримт хангалтгүй

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн, төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 374 мэдээллээс Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 374 мэдээллээс 23 төрлийн 1,128.1 сая төгрөгийн өглөг, 4 төрлийн 1,597.4 сая төгрөгийн авлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дарив сумын Эрчим хүч ААТҮГ-ын өмнөх оны шийдвэрийн үлдэгдэл 23.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 192.7 сая төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй аудитаар өмнөх оны зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Түлш халаалт, тээвэр шатахууны тооцоо, анхан шатны баримтын бүрдэл, авлага, өглөгийн тулгалт баталгаажуулалт, барагдуулалт, цалингийн урьдчилгаа, И баримт, зээлийг тооцоолол, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлсэн эсэхийг үзэх зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 377.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 15.1 сая төгрөгийн алдааг залруулж, 8.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 353.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлээ.

4.2.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд 15.1 сая төгрөгийн алдааг залруулав.

4.2.2 Төлбөрийн акт

Төрөөс хариуцан төлөх хэрэглэгчийн мэдээллийг тулган баталгаажуулахад 2.1 сая төгрөгийн төлбөрийг илүү нэхэмжлэн авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дугаартай тогтоолттой нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо

Төрийн аудитын байгууллагаас тавьсан төлбөрийн актаас 10 ажилтнаас 1.1 сая төгрөгийг илүү суутгасан, 5 ажилтнаас 1.1 сая төгрөгийг дутуу суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн

49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Ажилчдад олгосон урьдчилгаанаас 3.7 сая төгрөгийг дутуу суутгасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Зээлийн гэрээг давтан тулгахад гэрээнээс 0.7 сая төгрөгийг илүү тооцож төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Ихэс нуурын хишиг ХЗХ, иргэнтэй байгуулсан зээлийн эргэн төлөлтийн хувиар" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.2.3 Албан шаардлага

Худалдан авах ажиллагаа зарлаагүй 68.6 сая төгрөгийн түлээ нүүрс, 21.6 сая төгрөгийн шатахууны зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоол" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Зардлын 10%-ийг хэмнэж ажиллаагүй нь Засгийн газрын 2021 оны 2 сарын 7-ны өдрийн 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас, доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд алдагдалтай ажилласан байхад ажилчдад 5.1 сая төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Цалингийн цэс, дансны хуулга тулгахад 5 дугаар сарын 5.4 сая төгрөгийн амралтын цалингийн цэс байхгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 6.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана: 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах",

гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайланд элэгдлийн зардлыг 5.2 сая төгрөгөөр, өглөгийг зөрүүтэй тооцоо нийлэх боломжгүй, өглөгийг 1.6 сая төгрөгөөр, өмнөх онд өглөгөөр тайлагнасан 2 иргэнд олгох нүүрсний өглөг барагдуулсан гэж тайлагнасан боловч нотлогдоогүй 9.6 сая төгрөг, "Мон эко" ХХК өглөг 0.2 сая төгрөгөөр нэмэгдсэн ч нотлогдоогүй, өглөгөөр тайлагнаагүй 1 иргэнд өрийг барагдуулсан гэх 4.8 сая төгрөг олгосон нь зөрчлийг аудитаар нотлох боломжгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-т "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага тогтоолоо

Санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт 2.5 сая төгрөгөөр зөрүүтэй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Нягтлан бодогчийн дансанд 6.4 сая төгрөгийн гүйлгээ хийсэн анхан шатны баримтгүй байгаа нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 29.2.4.энэ хуулийн 11, 12, 15, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, энэ хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан бол нийтийн албанаас халах/ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага тогтоолоо.

Тайланд онд И баримтгүй нийт 118.5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний дүн санхүүгийн тайлангийн хувь оролцооны дүнгээс 246.9 сая төгрөгөөс зөрүүтэй нь Энэ нь Улсын бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т "Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд энэ хуулийн 6, 7, 8 дугаар зүйлд заасан улсын бүртгэлийн мэдээллийг хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй", Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2-т "Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр

заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ", 8.2.3-т "хувь нийлүүлсэн хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд 75.7 сая төгрөгийн нүүрс болон тээврийн хөлс төлсөн гэх боловч зарцуулсан баримтгүй бөөн дүнгээр зарлагдсан, орлого тодорхой бус анхан шатны баримт хангалтгүй нүүрсний тайлан гаргаагүй өглөг авлага тооцох боломжгүй, Жолоочийн тооцооны хуудасгүй 21.6 сая төгрөгийг зарцуулсан анхан шатны баримтгүй, шатахууны тайланг гаргаагүй, нягтлан бодох бүртгэлд шууд зардалд бичсэн зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар арилахгүй байна. Шилэн дансанд байршуулах 478.4 төгрөгийн 53 мэдээллээс 371.2 төгрөгийн 27 мэдээллийг байршуулаагүй, өмнөх онуудын санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын шийдвэрийн үлдэгдэл 194.7 сая төгрөгийн албан шаардлага, 23.3 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй, санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг санал дүгнэлт авсан зэрэг зөрчлүүд нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт /Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно., /, Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3 дахь заалт /Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана./, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Журам шинэчлэн батлах тухай" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т/Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.6-т/ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 13.7-т/Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

Тайлант онд тус байгууллагатай холбоотой 15.1 сая төгрөгийн алдаа, 151.1 сая төгрөгийн материаллаг 210.9 сая төгрөгийн материаллаг бус зөрчил илэрсэн өмнөх оны аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчил давтан гарч байгаа боловч байгууллага удирдлага тодорхой арга хэмжээ аваагүй. (хавсралтаар зөрчлийг үзүүлэв), Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өмчийн хувьд өмчлөгчийн эрхийг хуульд заасан хязгаарын хүрээнд тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, өмчийн удирдлагыг тухайн нэгжийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний хүрээнд Засаг дарга хэрэгжүүлнэ", 60 дугаар зүйлийн 60.1.2-т "аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж, үр дүнг хариуцах

4.2.4 Зөвлөмж

Аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аймгийн засаг даргад

1.1 Илрүүлэлт: Дарив дулаан Эрчим хүч ААТҮГ-ын газрын даргатай байгуулсан гэрээг дүгнэж ажиллаагүй байна.

1.1 Өгсөн зөвлөмж: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 7.1-т "Аймгийн Засаг Дарга нь Үйлдвэрийн газрын гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулан, жил бүрийн эцэст дүгнэж, цаашид хэрхэн ажиллах тухай саналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Суурин дулаан аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захиралд:

1.1 Илрүүлэлт: Дарив дулаан Эрчим хүч ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг төлөвлөгөөг тус оны 12 дугаар сард баталж өгсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 7.3-т "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас ирүүлсэн бизнес төлөвлөгөө, техник эдийн засгийн саналыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллах" гэсэн заалтыг мөрдөн гүйцэтгэл үр дүнг тооцох боломжтой хугацаанд эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг зохих журмаар баталж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	ТБОНӨХЭ	16	168.2	1	15.1	5	8.8	10	144.4	2	
Дүн		16	161.2	1	15.1	5	8.8	10	144.4	2	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	ТБОНӨХЭ	2	208.8					2	208.8		
Дүн		2	208.8					2	208.8		
Нийт дүн		18	377.0	1	15.1	5	8.8	12	353.2		